

## ТӨМӨР ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2019 оны 10 дугаар  
сарын 11-ний өдөр

Дугаар АГГ-19/240211/91

Улаанбаатар хот

Энэхүү гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г Монгол Улсын Иргэний хуулийн үүргийн нийтлэг үндэслэл, 343-358 дугаар зүйлийг тус тус баримтлан нэг талаас "МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ" ТӨХК-ийн Гүйцэтгэх захирал Р.БАТСҮХ (цаашид "Захиалагч" гэх), нөгөө талаас "УБТЗ" ХНН-ийн Зураг төслийн төвийн дарга Филиппов О.Л (цаашид "Гүйцэтгэгч" гэх) нар (цаашид хамтад нь "Талууд" гэх) ажил гүйцэтгэхтэй холбоотой харилцааг зохицуулах үүднээс дор дурдсан нөхцлөөр харилцан тохиролцож байгуулав.

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээний зорилго нь Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төслийн хүрээнд гэрээний 3.1-д заасан зураг төсөл боловсруулах /цаашид "Ажил" гэх/-ыг гүйцэтгэх, Захиалагчийн өмчлөлд хүлээлгэн өгөх, Захиалагч нь тохиролцсон ажлын хөлсийг төлөхтэй холбоотой үүсэх харилцаанд Талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж зохицуулна.

1.2. Гүйцэтгэгч нь зураг төслийг холбогдох хууль тогтоомж, захиргааны акт, стандарт, норм, нормативт нийцүүлэн энэхүү гэрээнд заасан хугацаанд боловсруулж Захиалагчид хүлээлгэн өгнө.

### Хоёр. Баталгаа

2.1 Гүйцэтгэгч нь дараах баталгааг гаргаж байна. Үүнд:

2.1.1 Гэрээний дагуу ажил гүйцэтгэх, гэрээнээс үүсэх эрх, үүргийг хэрэгжүүлэх шаардлагатай Тусгай зөвшөөрөл, эрхийг эрх бүхий байгууллагаас авсан, тэдгээр нь гэрээний үүргийг зохих ёсоор бүрэн гүйцэтгэж дуусах хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр, гэрээнд заагдсан ажлыг гүйцэтгэх мэргэжлийн боловсон хүчин, санхүүгийн бүрэн чадамжтай гэдгийг;

2.1.2 Гүйцэтгэгч нь ажлыг Хууль тогтоомж болон энэ гэрээнд заасан шаардлагад нийцүүлэн хүлээлгэж өгнө гэдгийг;

2.1.3 Талууд энэхүү Гэрээг байгуулах, хэрэгжүүлэхтэй холбогдуулан олж мэдсэн нөгөө талын үйл ажиллагаатай холбоотой нууц мэдээллийг тухайн талын зөвшөөрөлгүйгээр Хууль болон энэ гэрээнд зааснаас бусад тохиолдолд бусдад задруулахгүй, энэхүү гэрээнээс үүссэн харилцаанаас өөр бусад зорилгоор ашиглахгүй байхыг;

### Гурав. Гүйцэтгэх ажил, ажлын үр дүн

3.1 Энэхүү гэрээгээр нь Гүйцэтгэгч нь Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын 290-345 дугаар километр хоорондын нийт 55 км замын ул шорооны ажлын зураг төсөл боловсруулж Үүнд: Ул шорооны дагуу огтлолын зураг, хөндлөн огтлолын зураг, газар шорооны ажлын хэмжээ/, ажлын үр дүнг Захиалагчид хүлээлгэн өгнө.

3.2 Захиалагч боловсруулсан зураг төсөлд эрх бүхий байгууллагаар магадлал хийлгэж, дүгнэлт гаргуулна.



3.3 Ажлын үр дүн нь холбогдох хууль тогтоомж, захиргааны акт, стандарт, норм, нормативт нийцсэн байх ба Захиалагчийн өмч байна.

3.4 Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх хугацаанд шаардлагатай бичиг баримт болон Захиалагчийн шаардсан мэдээллийг бүрэн гаргаж өгнө.

### **Дөрөв. Ажил гүйцэтгэх хугацаа**

4.1 Гүйцэтгэгч нь гүйцэтгэсэн ажлыг 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдөр Захиалагчид хүлээлгэн өгнө.

4.2 Гэрээний 4.1-д заасан хугацааг Талууд харилцан тохиролцож сунгаж болно.

4.3 Захиалагчийн шаардсан тухай бүрт Гүйцэтгэгч нь хийгдэж буй ажлын талаар зохих мэдээлэл, тайланг хүргүүлнэ.

4.4 Ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй, эсхүл хугацаа хожимдуулж гүйцэтгэсэн нь Гүйцэтгэгчид Захиалагчийн зүгээс хууль болон энэ гэрээнд заасан алдангийн хэмжээг 0.01% болгон торгууль ногдуулах үндэслэл болно.

### **Тав. Ажлын хөлс, төлбөр тооцоо**

5.1 Энэхүү гэрээнд заасан ажлыг гүйцэтгэх үнэ, хөлс нь нийт **36.6 сая /гучин зургаан сая зургаан зуун мянга/ төгрөг** байна.

5.2 Ажлын хөлсөнд холбогдох НӨАТ болон холбогдох бусад төрлийн татвар, хураамж, үндсэн ажлын зардал, холбогдох бусад зардал бүгд багтсан болно.

5.3 Гэрээний үнийн дүнгийн 40%-ийг урьдчилгаа хөлс, төлбөр болгож Гүйцэтгэгчид Захиалагч төлнө.

5.4 Гүйцэтгэгч Захиалагчид ажлыг бүрэн хүлээлгэн өгснөөс хойш гэрээний үлдэгдэл төлбөрийн 60%-ийг ажлын 3 хоногт багтаан төлнө. Тус хугацаандаа багтаж шилжүүлэхгүй бол алданги 0.01% тооцно.

5.5 Гүйцэтгэгч баталгаажуулж ирүүлсэн болон Захиалагчийн эрх бүхий этгээд ажлын гүйцэтгэлийг хүлээн авч акт үйлдэж хүлээн авсанаар төлбөр хийх үндэслэл болно.

5.6 Гэрээний үнэ, ажлын хөлсийг нэхэмжлэлийн үндсэн дээр Гүйцэтгэгчийн Худалдаа хөгжлийн банкны 405025765 дансанд шилжүүлнэ.

5.7 Гэрээний үнийн 5 /тав/ хувийг Гүйцэтгэгч нь ажлын чанарын баталгаа болгон барьцаа хэлбэрээр үлдээх ба ажлыг магадлан баталгаажуулан дүгнэлт гаргах хүртэлх хугацаанп Захиалагчийн мэдэлд үлдэнэ.

### **Зургаа. Ажлын доголдлыг арилгах, гомдлын шаардлага гаргах**

6.1 Гүйцэтгэгч нь ажлыг чанаргүй гүйцэтгэсэн, алдаа, доголдолтой эсхүл Захиалагч, төрийн эрх бүхий хяналтын байгууллагын бичгээр өгсөн чиглэл, удирдамжийг зөрчиж гүйцэтгэсэн нь ажлын гүйцэтгэлийг хянах явцад болон гэрээнд заасан гомдлын шаардлага гаргах хугацаанд илэрсэн бол уг доголдол, зөрчлийг өөрийн хөрөнгөөр засч залруулах, арилгах, үүний улмаас үүссэн Захиалагч учирсан хохирлыг бүрэн хариуцах үүрэгтэй.

6.2 Гүйцэтгэгч ажлын үр дүнгийн доголдлын талаар санаатай нуун дарагдуулсан нь хожим илэрвэл тэрээр хариуцлагаас бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлөгдөх үндэслэл болохгүй бөгөөд Захиалагч учирсан шууд болон шууд бус хохирлыг бүрэн хариуцна.

6.3 Гүйцэтгэгч гэрээний нөхцөлийг зөрчсөн буюу гүйцэтгэсэн ажилд ямар нэг доголдол байвал Захиалагч энэ тухай гомдлын шаардлагыг ажил хүлээн авснаас хойш нэг жилийн дотор гомдлын шаардлага гаргах эрхтэй.

### Долоо. Ажил хүлээлцэх

7.1 Талууд ажлын гүйцэтгэлийг хүлээлцэхдээ тал тус бүрээс 2-оос доошгүй мэргэжлийн ажилтан оролцуулсан ажил хүлээлцэх комисс байгуулна.

7.2 Талууд гэрээний дагуу ажлын гүйцэтгэлийг хүлээлцсэнээс хойш 3 /гурав/ хоногийн дотор ажлын бусад бичиг баримтыг акт үйлдэн хүлээлцэнэ.

7.3 Бичиг баримтыг хүлээлцэхдээ Захиалагч түүний бүрдэл бүрэн гүйцэт, үнэн зөв эсэхийг шалгаж, эх хувийг хүлээн авна. Гүйцэтгэгч бичиг баримтын бүрдэл бүрэн гүйцэт, үнэн зөв эсэхийг бүрэн хариуцна.

7.4 Гүйцэтгэгч өөрийн архивт үлдээсэн хувиас шаардлагатай тохиолдолд Захиалагчийн хүсэлтийн дагуу үнэ төлбөргүй хуулбарлан авах боломжоор хангаж хуулбарыг баталгаажуулна.

7.5 Ажил хүлээлцсэнээр ажлын үр дүн нь Захиалагчийн өмчлөлд шилжинэ.

7.6 Талууд ажлын гүйцэтгэлийн хувь хэмжээ, явц, чанар, байдлын талаар харилцан тохиролцож чадаагүй, эсхүл аль нэг талын гаргасан тайлбар, үндэслэл, дүгнэлтийг нөгөө тал хүлээн зөвшөөрөгүй бол Захиалагчийн сонгосон шинжээчээр дүгнэлт гаргуулж, ажлын гүйцэтгэлийг хүлээн авна. Дахин шинжлэн томилох хүсэлт гаргасан тал өөрөө зардлаа хариуцана.

### Найм. Мэдээлэл солилцох, мэдээллээр хангах

8.1 Талуудын албан ёсны хаяг:

8.1.1 Захиалагч: "Монголын төмөр зам" төрийн өмчит хувьцаат компани

Улсын бүртгэлийн дугаар: 9012001025

Регистрийн дугаар: 5214203

Хаяг: Юнион бүлдинг, А блок, 7 давхар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13 хороолол, Нарны зам-62, Улаанбаатар /14230/

Утас: 7000-6622, 7010-6655

Имэйл: [info@mtz.mn](mailto:info@mtz.mn)

8.1.2 Гүйцэтгэгч: "Улаанбаатар төмөр зам"-ын Зураг төслийн төв

Улсын бүртгэлийн дугаар: 9019009041

Регистрийн дугаар: 2076675

Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар: 97/277-16

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3 дугаар хороо, Сөүлийн гудамж,

Утас: 86112201, 021242201

И-мэйл: [\[REDACTED\]](mailto:)

8.2 Гэрээний талууд гэрээг хэрэгжүүлэх хугацаанд шаардлагатай мэдээллийг зөвхөн албан бичгээр харилцан солилцож байна. Үүнд:

8.2.1 Захиалагч талыг төлөөлж мэдээлэл солилцох этгээд- МТЗ-ын Инженер, технологийн хэлтсийн дарга Д.Нямхагва;

8.2.2 Гүйцэтгэгч талыг төлөөлж мэдээлэл солилцох этгээд- “Улаанбаатар төмөр зам”-ын Зураг төслийн төвийн Замын зургийн хэлтсийн дарга Г.Түвшинбаяр.

8.3 Мэдээллийг бичгээр харилцахдаа факс, и-мэйл зэрэг цахим хэлбэрийг ашиглана.

8.4 Хойшлуулшгүй тохиолдолд Талууд мэдээллээ амаар болон утсаар солилцож болох боловч ийнхүү солилцсон мэдээллээ баталгаажуулж 48 цагийн дотор нөгөө талд бичгээр хүргүүлнэ.

8.5 Мэдээлэл солилцоонос үүсэх хохирлыг Захиалагч хариуцахгүй.

8.6 Захиалагч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай мэдээ баримт, судалгаа, зааварчилгааг Гүйцэтгэгчийн хүсэлтийн дагуу боломжит хугацаанд гаргаж өгнө.

### **Ес.Талуудын эрх, үүрэг**

#### **9.1 Захиалагчийн эрх, үүрэг:**

9.1.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхийг Гүйцэтгэгчээс шаардах;

9.1.2 Ажлын явцын тайланг Гүйцэтгэгчээс авах;

9.1.3 Гүйцэтгэгч талын үйл ажиллагаанд илэрсэн алдаа, зөрчлийн улмаас үүссэн аливаа хохирлыг нөхөн төлүүлэх, ажлын тайлан, дүгнэлтийн хувьд гарсан бүх алдаа, зөрчлийг үнэ төлбөргүй дахин хийлгэх, шинээр хийлгэх;

9.1.4 Шаардлагатай тохиолдолд ажлын гүйцэтгэлд нарийн мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн хяналт, шалгалт хийлгэх;

9.1.5 Захиалагч нь энэхүү гэрээнд заасны дагуу гэрээний үнэ, хөлсийг Гүйцэтгэгчид хугацаанд нь төлөх;

9.1.6 Гэрээт ажлыг хугацаанд нь гүйцэтгэхэд өөрсдийн зүгээс шаардлагатай туслалцааг Гүйцэтгэгч талд үзүүлэх;

9.1.7 Захиалагчийн зүгээс ажил хийж гүйцэтгэхтэй холбогдсон шаардлагатай мэдээ, мэдээлэлээр хангах;

9.1.8 Ажлын үр дүн, тайлан дүгнэлтийг эрх бүхий байгууллагаар хянан баталгаажуулах;

9.1.9 Энэхүү гэрээнд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

## **9.2 Гүйцэтгэгчийн эрх, үүрэг:**

- 9.2.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхийг Захиалагчаас шаардах;
- 9.2.2 Гэрээнд заасны дагуу гэрээний үнэ, хөлс авах;
- 9.2.3 Захиалагч талаас гаргаж өгөх ажлын хүрээндэх мэдээ материалыг боломжит цаг хугацаанд нь авах;
- 9.2.4 Гэрээнд заасан ажлыг хууль тогтоомж, захиргааны акт, стандарт, норм ба дүрмийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөх;
- 9.2.5 Ажлын үр дүн, тайлан дүгнэлтэд тусгагдсан норматив болон тооцооны үзүүлэлтүүдийн үнэн зөвийг бүрэн хариуцах;
- 9.2.6 Гэрээт ажил, тайлан дүгнэлттэй холбогдсон алдаа, зөрчил бий болсон тохиолдолд Захиалагчид дахин үнэ төлбөргүйгээр засч залруулах, хохирлыг барагдуулах арга хэмжээ авах;
- 9.2.7 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааг хариуцах үүрэгтэй.
- 9.2.8 Энэхүү гэрээнд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

## **Арав. Нууцлал**

10.1 Хууль болон гэрээнд зааснаас бусад тохиолдолд нөгөө Талын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр гэрээний талаарх аливаа мэдээллийг бусдад задруулахыг хориглоно.

10.2 Талууд, тэдгээрийн ажилтан гэрээний хэрэгжилттэй холбоотой баримт бичиг, мэдээллийг харилцан дамжуулах, солилцох, хадгалах хамгаалахдаа Төрийн болон албан нууцын тухай хууль, бусад хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журам, зааврыг чанд дагаж мөрдөх үүрэгтэй.

10.3 Талууд энэхүү гэрээний нөхцөл, ажил гүйцэтгэхтэй холбоотойгоор нөгөө талын шууд болон шууд бусаар олж авсан / гэрээ байгуулахаас өмнө эсхүл хойно, гэрээ цуцалсаны дараа/ аливаа мэдээллийг бусдад задруулахыг хориглоно.

10.4 Талуудын аль нэг нь энэ зүйлд заасан үүргээ зөрчсөний улмаас нөгөө талын бизнес, нэр хүндэд ноцтой хохирол учирсан, материаллаг хохирол учруулсан бол буруутай тал нь түүнийг бүрэн хариуцна.

## **Арваннэг. Гэрээг байгуулсанд тооцох**

11.1 Гэрээнд талуудын төлөөлөх эрхтэй этгээд гарын үсэг зурж баталгаажуулснаар гэрээ хүчин төгөлдөр болно.

11.2 Гэрээг Монгол хэлээр гурван хувь үйлдэх ба Гүйцэтгэгч хоёр хувийг, Захиалагч нэг хувийг хадгалах бөгөөд эдгээр нь хууль зүйн адил хүчинтэй байна.

11.3 Гэрээнд заагаагүй, тусгагдаагүй бусад харилцааг Талууд Монгол Улсын хууль тогтоомжид зааснаар шийдвэрлэнэ.

## **Арванхоёр. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах**

12.1 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцож

шийдвэрлэнэ.

12.2 Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд нөгөө Талдаа саналаа бичгээр хүргүүлэх бөгөөд тухайн саналд нэмэлт, өөрчлөлтийн үндэслэл, түүний төслийг тусгана.

12.3 Саналыг хүлээн авсан тал ажлын 1 хоногийн дотор хариу ирүүлэх үүрэгтэй бөгөөд Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, эсхүл цуцлах асуудлыг шийдвэрлэнэ.

12.4 Гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байна.

### **Арвангурав. Гэрээний зөрчлийг арилгах, гэрээ цуцлах**

13.1 Талууд гэрээний үүргийн зөрчлийг арилгах тухай нөгөө талдаа бичгээр мэдэгдэл хүргүүлэх бөгөөд мэдэгдлийг хүлээн авсан тал гэрээний зөрчлийг 5 хоногийн дотор арилгаж хариу мэдэгдэх үүрэг хүлээнэ.

13.2 Хэрэв зөрчил гаргасан Тал зөрчлийг 5 хоногийн дотор арилгах боломжгүй бол энэ тухай нөгөө Талдаа мэдэгдэх бөгөөд зөрчил арилгах хугацааг Талууд харилцан тохиролцож тогтооно.

13.3 Талууд гэрээг цуцлах саналтай байгаа бол уг саналаа нөгөө Талд бичгээр хүргүүлж, харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

13.4 Захиалагч нь дараах тохиолдолд гэрээг дангаар цуцлах эрхтэй. Үүнд:

13.4.1 Гүйцэтгэгч энэ гэрээний дагуу ажил гүйцэтгэх хугацааг 5 буюу түүнээс дээш хоногоор хэтрүүлсэн;

13.4.2 Гүйцэтгэгч ажил гүйцэтгэхдээ чанарын ноцтой алдаа, доголдол гаргасан бөгөөд Захиалагч ажлыг цаашид үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжгүй гэж үзсэн;

13.4.3 Гүйцэтгэгч нь ажлын доголдлыг боломжит хугацаанд арилгаагүй, эсхүл ийнхүү арилгахаас зайлсхийсэн;

13.4.4 Гүйцэтгэгчийн баталгаа, баримт бичиг нь хуурамч болох нь илэрсэн;

13.4.5 Гэрээгээр хүлээсэн үүргээ 2 ба түүнээс дээш удаа ноцтой зөрчсөн.

13.5 Гүйцэтгэгч дараах тохиолдолд гэрээг дангаар цуцлах эрхтэй. Үүнд:

13.5.1 Захиалагч төлбөрөө шилжүүлэх хугацааг 10 буюу түүнээс дээш хоногоор хэтрүүлсэн, цаашид боломжит хугацаанд шилжүүлэхгүй нь тодорхой болсон;

13.5.2 Захиалагч ажлын хамрах хүрээг өөрчилсөн нь энэхүү гэрээнд заасан ажлын хөлсийг нэмэгдүүлэх нөхцөл байдлыг бий болгосон бөгөөд Захиалагч нэмэлт санхүүжилтийг гаргахаас татгалзсан;

13.5.3 Гэрээгээр хүлээсэн үүргээ 2 буюу түүнээс дээш удаа ноцтой зөрчсөн.

13.6 Гэрээг цуцалсан тохиолдолд ийнхүү цуцалснаас хойш ажлын 3 хоногийн дотор гэрээ цуцалсан өдрөөр тасалбар болгон Захиалагч гуравдагч ажил гүйцэтгэгчээр ажлыг гүйцэтгүүлэх эрхтэй. Хэрэв зохих ёсоор гүйцэтгээгүй Гүйцэтгэгчийн ажлыг гуравдагч ажил гүйцэтгэгч үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжтой тохиолдолд тухайн ажилд ногдох Гүйцэтгэгчийн зардлыг Захиалагч төлөх тохиолдолд гуравдагч ажил гүйцэтгэгчтэй зөвшилцсөнийг үндэслэн тооцно.

### **Арвандөрөв. Хариуцлага**

14.1 Гүйцэтгэгч нь ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй бол ийнхүү хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн гүйцэтгэлийн үнийн дунгийн 0.1 хувьтай

тэнцэх хэмжээний алданги төлнө.

14.2 Энэ гэрээний 13.4-д заасны дагуу гэрээг Захиалагчийн санаачлагаар цуцалсан тохиолдолд Гүйцэтгэгч гэрээний нийт үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний торгууль хүлээх бөгөөд Захиалагчид учирсан хохирлыг бүрэн хариуцна.

14.3 Захиалагч нь энэ гэрээнд заасан үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй бол ийнхүү хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн гүйцэтгэлийн үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх хэмжээний алданги хүлээнэ.

14.4 Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн, гэрээнд заасны дагуу нэг талын санаачилгаар гэрээг цуцалсан бол буруутай тал нөгөө талд учруулсан аливаа хохирол болон зардлыг нөхөн төлнө.

14.5 Хэрэв аль нэг тал нь үүргээ биелүүлээгүй тохиолдолд нөгөө тал нь шаардах эрхээ хэрэгжүүлээгүй бол энэ нь эрхээсээ татгалзсан гэж тооцохгүй бөгөөд эрхээ хожим хэрэгжүүлэх, шаардлагатай арга хэмжээ авахад саад болохгүй.

14.6 Аль нэг тал Гэрээгээр хүлээсэн үүргээ давагдашгүй хүчин зүйлийн улмаас зохих ёсоор биелүүлээгүй болох нь нотлогдвол үүрэг давагдашгүй хүчин зүйлийг арилах хүртэл хугацаагаар хойшлогдоно. Захиалагч төрийн эрх бүхий байгууллагаас хамааралтайгаар гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд саад учирсан тохиолдолд Захиалагчийн үүрэг тухайн нөхцөлийг арилах хүртэл хугацаагаар хойшилно.

#### Арвантав. Маргаан шийдвэрлэх

15.1 Талууд харилцан хүндэтгэлтэй, бизнесийн ёс зүйг чанд сахиж, гэрээтэй холбоотой аливаа маргаан гарахаас урьдчилан сэргийлж ажиллана.

15.2 Энэхүү гэрээг тайлбарлах болон гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдож гарсан аливаа маргааныг Талууд харилцан тохиролцож шийдвэрлэхийг эрхэмлэнэ.

15.3 Талууд харилцан тохиролцоонд хүрэх боломжгүй тохиолдолд маргааныг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

#### ГЭРЭЭ БАИГУУЛСАН:

##### Захиалагчийг төлөөлж:

“Монголын төмөр зам” ТӨХК  
Гүйцэтгэх захирал Р.БАТСҮХ

Инженер технологийн  
хэлтсийн дарга

Д.Нямлхагва

##### Гүйцэтгэгчийг төлөөлж:

“УБТЗ” ХННийн  
төвийн дарга Зураг төслийн  
ФИЛИППОВ О.Л

Ерөнхий нягтлан

Ц.ТАМЖИД



МОНГОЛ-ОРОСЫН  
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН НИЙГЭМЛЭГ  
УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМ

210535 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг,  
Сөүлийн гудамж-42, Утас. 24-44-20, Факс: 24-30-44  
E-mail: ubtz@ubtz.mn

2019. 08. 15 № 10/1897

танаийн нийтийн №

Итгэмжлэл

Монгол Улсын Иргэний хуулийн 62 дугаар зүйл, Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг "Улаанбаатар төмөр зам"-ын дүрмийн 22 дугаар зүйлийн "ж"-д заасныг үндэслэн Замын дарга Д.Жигжиднямаа би, Улаанбаатар төмөр замын Зураг төслийн төвийн дарга Филиппов О.Л.-д тус нийгэмлэгийн нэрийн өмнөөс 50 сая хүртэл үнийн дунд 2019 оны хөрөнгө оруулалт, их барилга, их засварын төлөвлөгөөнд багтсан гадны байгууллагатай салбар замын хэвгийн хэмжилт хийх, зураг төсөл боловсруулах, тус төвийн боловсруулсан зураг төслийг Зам, тээврийн хөгжлийн төв болон Барилгын хөгжлийн төвөөр магадлал хийлгэх гэрээ байгуулах итгэмжлэл олгож байна.

Филиппов О.Л. нь гэрээ байгуулахдаа Монгол Улсын хууль тогтоомжк, Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг "Улаанбаатар төмөр зам"-д мөрдөж буй Замын даргын 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн A-220 дугаар тушаалаар батлагдсан "Гэрээ байгуулах журам" болон 2019 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн A-02 дугаар тушаалаар батлагдсан "Бараа, ажил үйлчилгээ нийлүүлэгчийг сонгон шалгаруулах журам"-ыг тус тус баримтлан гэрээг холбогдох алба, хэлтсээр хянуулах, гэрээний гүйцэтгэлд хяналт тавих үүрэг хүлээнэ.

Итгэмжлэл нь 2019 оны 12 дугаар сарын 31 хүртэл хугацаанд хүчинтэй.

Энэхүү итгэмжлэлийг гуравдагч этгээдэд дамжуулах эрхгүй.

Итгэмжлэгдсэн төлөөлөгч нь бүрэн эрхээ шударгаар, төлөөлүүлэгчийн буюу "Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн хууль ёсны ашиг сонирхолд нийцүүлэн хэрэгжүүлэх ба үүргээ биелүүлээгүйгээс төлөөлүүлэгчид буюу "Улаанбаатар төмөр зам" ХНН-т учирсан гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй.

ДАРГА

Д.ЖИГЖИДНЯМАА

164193120

УБ-2

Монгол Улсын Засгийн газрын  
2004 оны 20 дугаар тогтоолоор батлав.



МОНГОЛ УЛС  
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ  
000013585

2008.04.03

/Бүртгэсэн он, сар, өдөр/

9012001025

/Улсын бүртгэлийн дугаар/

5214203

/Регистрийн дугаар/

Монголын төмөр зам

Төвийн өмчт хувьцаат компани

/Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр/

Дүрэм

/Үсгэн байгуулах баримт бичиг/

Тогтолц

/шийдвэрээний нэр/

189

/дугаар/

2008.03.20

он, сар, өдөр

511000

/код/

Гадаад худалдаа

/Нийссэн эрхлэх үйл ажиллагааны чигээл/

/код/

/Пуслах эрхлэх үйл ажиллагааны чигээл/

Хугацаагүй

хугацаа

1


/гишүүдийн тоо/

10.080,0

/өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгсөөр/

Чингэлтэй, 1-р хороо, Энх тайвны өргөн чөлөө, ЗГ-ын 4-р байр - 404 тоот, утас1:264451, утас2:, факс:

/Хуулийн этгээдийн албан ёсны хаяг/



Улсын бүртгэлийн вэрийн газрын  
Хуулийн этгээдийн бүртгэлийн газар

/Бүртгэсэн байгууллагын нэр/

**Харилцах банкны бүртгэл:**

Харилцагч банкны нэр	Дансны төрөл	Дансны дугаар	Бүртгэсэн ажилтан, тэмдэг
ХХБ Баянзүрх 804 салбар Худалдаа хөгжлийн банк	Төврөгийн Валютын	404187856 404187857	Ц.Цэдэндорж Б.Аваризд

**Хуулийн этгээдийн уусгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн бүртгэл:**

Д/д

Нэмэлт, өөрчлөлтийн агуулга

Огноо

Бүртгэсэн

Ажилтан, тэмдэг

1. Дүрмийн сан 12520-р нэмээдэж 22600.0 мянган төгрөг болж, уусгэн байгуулаачийн тоо 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2008.05.07	Ц.Цэдэндорж
2. Баянзүрх, 4-р хороо, 2-р хороолол, ОУЗГТХТ-н, 1 дахьхарт, ШХ: утас1: 243411, утас2: 243413, факс: хаягийн шинээр бүртгэв.	2010.12.22	Б.Аваризд
3. 601000,Даланзадгад-Сайншанд-Баруун-Урт-Чойбалсангийн чиглэлд төмөр замын суурь бүтэц барих эрхлэх туслах үйл ажиллагаа. З жилийн хувацаатайгаар шинээр бүртгэв.	2011.01.10	Ч.Батцэцэ
4. Дүрмийн сан 20705100-р нэмээдэж 20727700,0 мянган төгрөг болж, уусгэн байгуулаачийн тоо 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2011.03.30	Г.Элзийбаяр
4. Чингэлтэй, 1-р хороо, Жавшигдажын гудамж, Финанс төвийн байд тост, Утас1:336511, Утас2., Факс:336644 хаягийн шинээр бүртгэв.	2011.11.08	Ц.Цэнээл
5. 749900, Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх туслах үйл ажиллагаавыг шинээр бүртгэв.	2012.06.19	Ш.Цэнгэл
1. Хөгжлийн банкинд 3600000.196 тоот овалстын данс нээснийг бүртгэв	2013.02.27	В.Хөнгөнжурэн
9. Гүрээдорж овогтой Батцэцээн -г захирал-р томилсныг бүртгэв.	2013.02.27	В.Хөнгөнжурэн
10. Гүрээсгембуу овогтой Батсаихан -г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2014.05.08	Д.Аюурдаалан
11. Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, юниско, Юнион бьюндийн төв 14 дээхэр С блок тоот, Утас1: 70006622, Утас2, Факс 70106644 хаягийн шинээр бүртгэв.	2014.10.07	В.Хөнгөнжурэн
12. 4912 Төмөр замын тээвэр зуучлал /2013.04.16-2016.04.15/-ний өдөр хүртэл эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв. 4210 Төмөр замын суурь бүтэц барих /2013.03.20-2018.03.20/-ний өдөр хүртэл эрхлэх үйл ажиллагаа шинээр бүртгэв.	2014.10.07	В.Хөнгөнжурэн
13. Дангаа обогтой Ганбат -г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2015.03.13	Д.Аюурдаалан
14. Улаанбаатар банк банкны 25770005 тоот овалстын данс нээснийг бүртгэв. Улаанбаатар банк банкны 2577000972 тоот овалстын данс нээснийг бүртгэв.		
15. Улаанбаатар банк банкны 2677000971 тоот овалстын данс нээснийг бүртгэв.		
16. Дорноговь аймагийн Замын-Үүд суман дахь салбар' Дорноговь, Замын-Үүд, 1-р баатар, , , 0 байрлах салбар өнгөтэй бүртгэв.	2015.04.30	Г.Амархаджийн
17. Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, 13,, "UVN" центр, 8 дахьхарт, тоот, Утас1: 70006622, Утас2, Факс 70106644 хаягийн шинээр бүртгэв.	2016.03.23	Я.Алтуухийн
18. Хүнисгжаргал овогтой Хэрлэн -г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2016.11.01	М.МОнголжан
19. Болд овогтой Цэнээл -г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2017.12.13	Э.Эрдэнэбилээ

Энэхүү тэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.  
Улсын бүртгэлийн тэрчилгээ засвартай бол хүчингүй.